

22nd July 2022

Independent Director Report of Xacbank – Q2 2022

I, **Niraj Vedwa**, hereby report on the delivery and performance of my duties as Independent Director of the Board of Directors for Xacbank (XB) during the 2nd Quarter of 2022 (the Reporting Period). I was appointed ID in June 2019 and my role was extended for 2 years in April 2021. As Independent Director of Xacbank, my role and duties are guided by the following laws and regulations:

- the Company Law of Mongolia,
- the Banking Law of Mongolia,
- the "Corporate Governance Principles of the Bank" issued by the BoM,
- the "Procedure on Independent director of a bank" issued by Financial Stability Counsel,
- the Charter of Xacbank
- and bylaw regulation documents.

During the Reporting period:

- I. I have attended via video conference, Q2 2022 Board meetings of the Board of Directors held during the Reporting Period and oversaw the Bank's activities, Clarified issues in the BRMC /BAC and GNC meetings with the management, and gave suggestions on Digital Banking to facilitate a smooth transformation.

April 12th 2022 - Attended XB Board Meeting which had the IPO Prospectus charters to be discussed and a decision to be made. All Board members were present in the meeting which covered IPO Prospectus / Xacbank JSC Draft Dividend Policy /XB JSC Charter / Summary of Legal opinion on IPO of XB LLC Securities registration at Registry of Securities for Public Offering. Post discussions it was decided to hold a EGM on 25nd April & 27th April.

April 25th 2022 – Attended XB Extraordinary Board Meeting which covered IPO discussions and recommendations to the Shareholders (External Legal Opinion Summary / BDO XB Valuation Report / XB JSC Charter Draft / Dividend Policy / Prospectus (IPO Listing, Size, Pricing, Allocation rule & cost of IPO / Underwriters Presentation and independent review letter / IPO Prospectus. All Board Members attended and there were comprehensive discussions on all agenda items.

April 26th 2022 – Attended Annual General Meeting of Shareholders of XB which covered XB Annual Results and Financials / Macroeconomic outlook / Impact of Russia Ukraine war / Update on IPO and Re-Structuring. Independent Director report was also tabled.

April 27th 2022 - Attended XB Board Meeting which covered IPO Listing size / Pricing / Allocation / Prospectus / Restructuring resolution / Application forms and Amendment to Clause 3.1 of Shareholders agreement. Also discussed was the date for announcement to EGM regarding IPO.

May 16th 2022 - Attended XB Extraordinary Board Meeting (EGM) which covered XB LLC Charter Amendment re increase to 12 Board Directors / Amendment to Clause 3.1 of Shareholder Agreement / Outside Legal Opinion Summary / XB JSC Charter Draft / Dividend Policy / Prospectus (IPO Listing, Size, Pricing, Allocation rule & cost of IPO / Underwriters Presentation and independent review letter / IPO Prospectus. There were comprehensive discussions on all agenda items.

June 20th 2022 – Attended the XB EGM (Extraordinary Board Meeting) held on 20th June to discuss IPO related matters and decision on next steps on IPO & Corporate Restructuring options.

June 28th 2022 – Attended BRMC (Bank Risk Management Committee) / BAC (Bank Audit Committee) and GNC (Governance & Compensation Committee) meetings

BRMC – As member of BRMC, I attended the meeting with an agenda covering XB risk report as off May 2022 / Risk Appetite Statement Annual Review 2022 / Write-offs Loans & Leasing) Board Decisions /Sanctions on Russia and impact / Compliance Update as off May 2022 / Approval of Related party transactions.

BAC – As member of XB Audit Committee (BAC), I attended the meeting where the agenda covered various Audit Reports – Reports on Continuous Auditing /Onsite audit of Rural Branches / IT Cyber Management / Related party Quarterly reporting / E&Y management letter from 2021 year end audit.

GNC – While I am not a member of GNC, I participated in the GNC meeting that covered XB long term Incentive Plan / Update on selection of 2 vacant Independent Director positions / Employee Loan & Mortgage T&C Annual Review / Board & Director Evaluations Summary Results


June 29th 2022 – Q2 Board Meeting – Attended XB Board meeting that covered reports of BRMC / BAC and GNC / Updates on previous Board meetings and recommendations / Management Report May 2022 that covered Economic, Political and Covid update / Business Line Performance / NIM analysis / Financial results / IPO Update / Asset Quality Review (AQR) / IT Update / D&O Insurance Update / Sanctions on Russia and impact.

As Independent Director, I am of the view that the Bank has been professional & prudent with Strategic Planning, Risk management, Corporate Governance, Regulatory

Compliance, Digital Transformation, KPI Execution and monitoring. Bank's key metrics and ratios are well within budgets and policy guidelines. Bank Board has met more than 6 times to discuss the IPO & Corporate Re-Structuring. This has been given the highest priority so that there is 100% compliance to BOM Guidelines.

As per Article 79.3 of the Company Law, an independent member of the Board of Directors shall have the following additional obligations in addition to the rights and obligations of the other members:

- 79.3.1. monitor whether the activities, policies and decision of the Board of Directors and of the executive body negatively affects the interests of the company, whether the activities are in compliance with the laws, rules and procedures, prevent from violations or conflicts, demand from the relevant person to eliminate any violations, if such demand is not complied with, to submit such matter for consideration by the Board of Directors and consequently, to submit the demand to convene a shareholders meeting;
- 79.3.2. to guide the executive body in respect of maintaining the transparency and accessibility of the company's activities, monitor and make demands in respect thereof;
- 79.3.3. to take part in the shareholder's meetings in person, and to inform of any different views taken in respect of the decision rendered by the Board of Directors, respond to questions by the shareholders and to make clarifications.
- During the reporting period in accordance with Article 79.3, item 79.3.3.1 as Independent Director, My every vote was made with consideration of all stakeholders (the Bank, shareholders, employees and customers), regulatory requirements and in line with Bank's internal rules and procedures



Niraj Vedwa

Independent Director on Board - Xacbank

ХасБанкны Хараат бус гишүүний тайлан – 2022 оны 2 дугаар улирал

Нираж Ведва миний бие ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр ажилласан 2022 оны 2 дугаар улирал (тайлант хугацаа)-ын хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын тайлангаа үүгээр хүргүүлж байна. Миний бие 2019 оны 6 дугаар сард ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдсон бөгөөд 2021 оны 4 дүгээр сард 2 жилийн хугацаатайгаар улиран томилогдсон. ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд дараах хууль тогтоомжийг удирдлага болгож ажиллаж байна:

- Компанийн тухай хууль
- Банкны тухай хууль
- Монголбанкны “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”
- Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн “Банкны хараат бус гишүүний ажиллах журам”
- ХасБанкны дүрэм
- Холбогдох бусад хууль тогтоомж, баримт бичиг

Тайлант хугацаанд:

1. Тайлант хугацаанд болсон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 2 дугаар улирлын хуралд цахимаар оролцож, банкны үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо/Аудитын хороо болон Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны хурлуудад асуудлыг тодруулах байдлаар оролцож, түүнчлэн Цахим банкны шилжилтийг хэрэгжүүлэх талаарх асуудалд саналаа өгч ажилласан.

2022 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр – IPO танилцуулга, дүрмийг хэлэлцэж, шийдвэр гаргасан ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцсон. IPO танилцуулга / ХасБанк ХК-ийн Ногдол ашгийн бодлогын төсөл / ХасБанк ХК-ийн дүрэм / ХасБанк ХХК-ийн анх удаа нийтэд санал болгох хувьцааг нийтэд санал болгох үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэх бүртгэлийн асуудлаарх хууль зүйн дүгнэлтийн хураангуйг хэлэлцсэн хуралд Төлөөлөн удирдах зөвлөлийн бүх гишүүд оролцсон болно. Хэлэлцүүлгийн дараа Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хурлыг 4 дүгээр сарын 25 болон 27-ны өдрүүдэд хийхээр шийдвэрлэсэн.

2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр – IPO талаар болон Хувьцаа эзэмшигчдэд өгөх зөвлөмж (Хөндлөнгийн хууль зүйн дүгнэлтийн хураангуй)/ БДО ХХК-ийн ХасБанкны Үнэлгээний тайлан / ХасБанк ХК-ийн дүрмийн төсөл / Ногдол ашгийн бодлого / Танилцуулга (IPO жагсаалт, хэмжээ, үнэ, IPO хуваарилах дүрэм ба зардал) /

андеррайтерийн танилцуулга ба хараат бус дүгнэлт / IPO танилцуулгыг хэлэлцсэн ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хуралд оролцсон. Тус хуралд Төлөөлөн удирдах зөвлөлийн бүх гишүүд оролцож, хэлэлцсэн асуудал бүрт санал өгсөн.

2022 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр – ХасБанкны жилийн үр дүн болон санхүүгийн үзүүлэлт / Макро эдийн засгийн хэтийн төлөв / ОХУ Украйны дайны нөлөө / IPO болон өөрчлөн байгуулах асуудлаарх шинэ мэдээллийн талаар хэлэлцсэн ХасБанкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон. Мөн Хараат бус гишүүний тайланг танилцуулсан.

2022 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр – IPO жагсаалтын хэмжээ / Үнэ / Хуваарилалт / Танилцуулга / Өөрчлөн байгуулах шийдвэр / Өргөдлийн маягт болон Хувьцаа эзэмшигчдийн гэрээний 3.1 дэх хэсэгт оруулсан нэмэлт өөрчлөлтийн талаар хэлэлцсэн ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцсон. Мөн IPO-той холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хурлыг хуралдах товын талаар хэлэлцсэн.

2022 оны 5 дугаар сарын 16-ны өдөр – ХасБанк ХХК-ийн дүрмийн ТУЗ-ийн гишүүн 12 болж нэмэгдсэнтэй холбоотой нэмэлт өөрчлөлт / Хувьцаа эзэмшигчдийн гэрээний 3.1 дэх хэсэгт оруулсан нэмэлт өөрчлөлт / Хөндлөнгийн хууль зүйн дүгнэлтийн хураангуй / ХасБанк ХК-ийн дүрмийн төсөл / Ногдол ашгийн бодлого / Танилцуулга (IPO жагсаалт, хэмжээ, үнэ, хуваарилах дүрэм ба зардал) / андеррайтерийн танилцуулга ба хараат бус хяналтын захидал / IPO танилцуулгын талаар хэлэлцсэн ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хуралд оролцсон. Тус хуралд Төлөөлөн удирдах зөвлөлийн бүх гишүүд оролцож, хэлэлцсэн асуудал бүрт санал өгсөн.

2022 оны 6 дугаар сарын 20-ны өдөр – 6 дугаар сарын 20-ны өдөр хуралдсан, IPO-той холбоотой асуудлыг болон IPO, компанийг өөрчлөн байгуулах хувилбарын дараагийн алхмын талаарх шийдвэрийг хэлэлцсэн ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хуралд оролцсон.

2022 оны 6 дугаар сарын 28-ны өдөр – ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо / Аудитын хороо болон Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны хурлуудад оролцсон.

Эрсдэлийн удирдлагын хороо – Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүний хувьд миний бие 2022 оны 5 дугаар сарын байдлаарх ХасБанкны эрсдэлийн тайлан / 2022 оны хүлээн зөвшөөрөх эрсдэлийн үзүүлэлт / (сангаас хаах зээл болон санхүүгийн түрээс) Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр / ОХУ-ын эсрэг авсан хориг арга хэмжээ болон түүний нөлөө / 2022 оны 5 дугаар сарын байдлаарх хянан нийцүүлэлтийн талаарх шинэ мэдээлэл / Холбогдох этгээдийн гүйлгээг батлах асуудлыг хэлэлцэх хуралд оролцсон.

Аудитын хороо – ХасБанкны Аудитын хорооны гишүүний хувьд миний бие олон төрлийн Аудитын тайлангууд – үргэлжлэн хийгдэж буй аждитын тайлангууд / орон нутгийн салбаруудад хийсэн газар дээрх аудит / Мэдээллийн технологийн кибер удирдлага / Холбогдох этгээдийн улирлын тайлан / Эрнст энд Янгийн 2021 оны жилийн эцсийн аудитын талаарх удирдлагын захидлын талаар хэлэлцсэн хуралд оролцсон.

Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо – Миний бие Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны гишүүн биш боловч ХасБанкны урт хугацааны урамшууллын төлөвлөгөө / Хараат бус гишүүний 2 сул орон тооны сонгон шалгаруулалтын талаарх шинэ мэдээлэл / Ажилтнуудын зээл болон ипотекийн зээлийн гэрээний жилийн хяналт / ТУЗ болон ТУЗ-ийн гишүүдийн үнэлгээний хураангуй үр дүнгийн талаар хэлэлцсэн Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны хуралд оролцсон.

2022 оны 6 дугаар сарын 29-ний өдөр – Төлөөлөн удирдах зөвлөлийн 2 дугаар улирлын хурал – Эрсдэлийн удирдлагын хороо / Аудитын хороо болон Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны тайлан / өмнөх Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал болон зөвлөмжийн талаарх шинэ мэдээлэл / Эдийн засаг, улс төр болон Ковидын асуудлыг хамруулсан 2022 оны 5 дугаар сарын Удирдлагын тайлан / Бизнес нэгжүүдийн гүйцэтгэл / Цэвэр ашгийн маржинд хийсэн дүн шинжилгээ / Санхүүгийн үр дүн / IPO-ийн талаарх шинэ мэдээлэл / хөрөнгийн чанарын үнэлгээ / Мэдээллийн технологийн шинэ мэдээлэл / Захирал болон ажилтнуудын хариуцлагын даатгалын талаарх шинэ мэдээлэл / ОХУ-ын эсрэг авсан хориг арга хэмжээ болон түүний нөлөөний талаар хэлэлцсэн ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцсон.

Хараат бус гишүүний хувьд миний бие Банкны Стратегийн төлөвлөгөө, богино, дунд, урт хугацааны зорилт, эрсдэлийн удирдлага, компанийн засаглал, хянан нийцүүлэлт, цахим шилжилт, гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтийн хэрэгжилт ба хяналтыг мэргэжлийн бөгөөд оновчтой хэрэгжүүлсэн гэж үзэж байна. Банкны түлхүүр үзүүлэлтүүд болон харьцаа нь төсөвтөө багтаж, бодлогод бүрэн нийцсэн. Банкны Төлөөлөн удирдах зөвлөл нь IPO болон компанийг өөрчлөн байгуулах асуудлыг хэлэлцэхээр 6-аас илүү удаа уулзсан. Монголбанкны удирдамжид 100% нийцүүлэхийн тулд өндөр ач холбогдол өгч байгаа болно.

Компанийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.3 дахь хэсэгт “Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн нь бусад гишүүний адил эрх, үүрэгтэй байхаас гадна дараах нэмэлт үүргийг хүлээнэ:

- 79.3.1. төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь тухайн компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлсөн эсэх, үйл

ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн эсэхэд хяналт тавих, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчил илэрвэл уг зөрчлийг арилгахыг холбогдох этгээдээс шаардах, шаардлагыг эс биелүүлбэл уг асуудлыг төлөөлөн удирдах зөвлөлд тавьж шийдвэрлүүлэх, улмаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах шаардлагыг хүргүүлэх;

- 79.3.2. компанийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч, хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах;
- 79.3.3. хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцож, төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах, тодруулга хийх.
- Тайлангийн хугацаанд Компанийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.3.1 дэх заалтад заасны дагуу хараат бус гишүүний хувьд миний өгсөн санал бүр оролцогч талууд (Банк, хувьцаа эзэмшигчид, ажилтнууд болон харилцагчид)-ыг харгалзан үзсэн, хууль тогтоомжийн шаардлага, Банкны дотоод дүрэм, журамд нийцсэн байсан.

Нираж Ведва

ТУЗ-ийн хараат бус гишүүн - ХасБанк